



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/174

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Сагсан бөмбөгийн U16 насны Улсын аварга шалгаруулах тэмцээнд Ховд аймгаас оролцох баг тамирчдын зардлын дэмжлэгт 3,150,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дэмжлэгт зарцуулагдах 3,150,000 (Гурван сая нэг зуун тавин мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний 5.3-д тусгагдсан "Соёл, спортын салбарын хөтөлбөр" төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбат) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Х.Батболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 21-ний өдрийн
А/174 дүгээр захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ЗАДАРГАА

Д/д	Арга хэмжээний зардал	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт төсөв
1	2	3	4	5
1	Тамирчдын байрны зардал	13 хүн 7 хоног	225,000	1,575,000
2	Багш дасгалжуулагч	2 хүн 7 хоног	225,000	1,575,000
Нийт				3,150,000

-oOo-